



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/3025

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах аж ахуй нэгжийн хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр (1-р сургуулийн урд талд)-т байршилтай Төмөр-Очир овогтой Дашцэрэн (ЗГ:87042512)-ийн гаражийн зориулалттай 18 м.кв (0,0018 га) газрыг Баянсан овогтой Эрдэнэтуяа (ЗЮ:62062001)-д зориулалтаар нь шилжүүлж 23 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/593 дугаар захирамжийн иргэн Т.Дашцэрэн-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000457343 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ